

---

## Бага Сургуулийн Элсэлтийн бодлого 2024-2025

### 1. Зорилго

- Улаанбаатар дах Америк Сургууль нь англи хэлтэй орчинд олон улсын стандартад нийцсэн боловсролыг олгох зорилготой боловсролын байгууллага юм.
- Улаанбаатар дах Америк Сургууль нь эцэг эх болон сурагчийг хүйс, гарал үүсэл, шашин шүтлэг, яс үндсээр нь үл ялгаварлан жигд хандана.
- Улаанбаатар дах Америк Сургууль нь сурагч бүрийг өөрийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, сурлага, зан байдал, нийгэмшил, соёлын хувьд өсөн дэвжих боломжийг олгох тэнцвэртэй сурах орчинг бүрдүүлэхийг зорино.

### 2. Элсэлтийн бодлого, практик

- Сургалт хариуцсан захирал, координатор нар сурагчийн элсэх шийдвэрийг гаргана.
- Монгол хэл, гадаад хэлнээс бусад бүх хичээл англи хэл дээр явагдана.
- Нэг ангид байх сурагчийн тоог 24 байлгана.
- Эцэг эхийн хүсэлтээр сурагчийг анги алгасуулан сургахыг зөвшөөрөхгүй. Зөвхөн сурагчийн насны шаардлагыг харгалзан ангид хуваарилна.
- УАС-ийн одоогийн сурагчид дараагийн хичээлийн жилд дэвшин суралцахад суудлын баталгааны төлбөрийг сургуулиас заасан хугацаанд төлснөөр ангийн жагсаалтанд орно. Харин дараа жилийн суудлын баталгааны төлбөр болон эцэг эхтэй хийх гэрээнд гарын үсэг зураагүй тохиолдолд одоогийн сурагчийн суудлыг хадгалж үлдэхгүй. Мөн одоо сурч буй сурагчийн төрсөн эгч ах дүүсийг элсэлтийн шаардлагад нийцвэл элсэлтийн бүртгэлийг эрт хийж болно.
- Элсэлтийн багц материалыг нэг бүрчлэн бүрдүүлсэний дараа тухайн хүүхдийг бүртгэн авна. Хэрэв аль нэг материал дутуу бүрдүүлсэн бол бүртгэл хүчингүй болно.
- Элсэлтийн анкетийг ямар нэг байдлаар буруу бөглөсөн тохиолдолд тухайн хүүхдийг бүртгэж авахгүй.
- Шаардлагатай бүх төлбөр хийгдсэний дараа тухайн хүүхдийг хичээлд суулгана.
- Эцэг эхчүүдийн зүгээс анги хуваарьлалтын талаар хүсэлт хүлээн авахгүй болно.
- Нэг гэр бүлийн 2 - 3 хүүхэд хамтдаа Бага, Дунд, Ахлах сургуульд тус тус элсэн орж байгаа тохиолдолд элсүүлэх эцсийн шийдвэрийг 2 сургуулийн захиргаа гаргана.
- Сурагч хичээлд хамрагдаж эхэлсний дараа сургуулийн захиргааны зүгээс сургуулийн шалгуур үзүүлэлтүүдэд тэнцэхгүй болохыг тогтоовол тухайн сурагчийг сургуулиас гаргана. Хичээлд суугаагүй өдрийн сургалтын төлбөрийг эргүүлэн олгоно.

### **3. Элсэлтийн үйл явц**

- Элсэлтийн маягтыг бүрэн бөглөж, холбогдох материалыг бүрдүүлсний дараа Сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Бүртгэлийн хураамжийг төлж материал бүрэн гүйцэт бүрдсэн бол сургалтын алба эцэг эхтэй холбогдож, шалгалт авах хуваарийг мэдэгдэнэ.
- Урьд нь хамрагдсан сургуулиас нь үл хамааран англи хэлээр түвшин тогтоох элсэлтийн шалгалтыг сурагч бүрээс авна.
- Сургалт хариуцсан координатор эсвэл сургуулиас томилогдсон эрх бүхий ажилтан элсэлтийн ярилцлагыг тухайн сурагчтай хийнэ. Элсүүлэх шийдвэрийг гаргахад тухайн хүүхдийн насны шаардлага хангасан байдал, өмнөх сургуульд сурч байсан сурлагын дүн, ярилцлагын болон элсэлтийн шалгалтын дүн тус бүр дээр үндэслэн шийдвэрлэнэ.
- Сургуульд элссэний дараа Сургалт хариуцсан захирал болон координатор элсэлтийг баталгаажуулж, зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурах бөгөөд шинэ сурагчийн орох анги, бахархлын багт хувиарлана
- Сургуулийн захиргааны зөвшөөрлийн дагуу сургалтын албанаас сурагчийн эцэг эхтэй холбогдож, сурагчийг элсүүлэх талаарх шийдвэрийг элсэлтийн шалгалт авснаас хойш 1-3 ажлын өдрийн дотор мэдэгдэнэ
- Тухайн сурагчийг элсүүлэх шийдвэр гарсны дараа сургалтын алба санхүүгийн албад мэдэгдэж, санхүүгийн алба сургалтын төлбөрийн нэхэмжлэхийг эцэх эх, асран хамгаалагчид руу явуулна.
- Сургалт хариуцсан ажилтан хуваарилагдсан ангийн багш болон бусад багш нарт шинээр элсэн орж буй сурагчийн мэдээллийг өгнө.

### **4. Хэлний шаардлага**

- Сурагч амжилттай сурах үндэс нь манай сургуулиас тавьж буй англи хэлний түвшингийн шаардлагыг хангасан байна.
- Бэлтгэл, 1 дүгээр ангид элсэгчдэд англи хэлний түвшин шаардлагагүй.
- Англи хэлний нэмэлт туслалцаа шаардлагатай сурагчдыг Англи хэл хоёрдогч хэл хөтөлбөрт хамруулна.

### **5. Элсэлтийн шалгалтын бодлого**

- Шинээр элсэн орж буй сурагчдаас Англи хэлний түвшин тогтоох, Математик болон бусад шаардлагатай хичээлээр элсэлтийн шалгалт авна.
- Англи хэл тухайн хүүхдийн эх хэл, хоёрдогч хэл байхаас үл хамааран сурагч бүрээс англи хэлний төвшин тогтоох шалгалт авах ба тухайн хүүхэд англи хэлтэй орчинд хэдэн жил сурсан нь үл хамаарна.

---

**6. Насны хязгаар болон хичээлийн жилийн дундаас элсэн орох**

- Шинээр элсэн орж байгаа сурагч зөвхөн өөрийн насны ангиллын шаардлагыг хангахаас гадна өмнөх ангиа бүрэн дүүргэсэн тохиолдолд тухайн ангид элсэн орно.
- Хичээлийн жилийн хугацаа нь өөр байдаг газраас ирсэн сурагч /тухайлбал 1-11-р сар хүртэл үргэлжилдэг/ манай сургуулийн хичээлийн жилийн эхнээс элсэн орж байгаа тохиолдолд тухайн сурч байсан ангиа үргэлжлүүлэн сурна. Харин хичээлийн жилийн дундаас элсэн орж буй сурагч сурч байсан ангиа үргэлжлүүлнэ.
- Хичээлийн жилийн дундаас орж байгаа сурагчид амжилттай бүрэн дүүрэгсэн ангийн дараагийн ангид орно.
- Семестрийн дундуур шинээр элссэн хүүхэд тухайн семестрийн төлбөрийг бүтэн төлнө.

**7. Тусгай анхаарал шаардагдах сурагч**

- Тусгай анхаарал шаардагдах сурагчийг шинээр элсүүлэн авах асуудлыг сургалт хариуцсан захирал шийдвэрлэнэ. Ингэхдээ тухайн сурагчийн хэрэгцээг сургууль хангаж чадах эсэхийг тогтоосон нөхцөлд элсүүлнэ.
- Америк дунд сургууль тухайн хүүхдийн тусгай хэрэгцээг хангах боломжгүй нь тогтоогдвол элсүүлэн авахаас татгалзах эрхийг Сургалт хариуцсан захирал эдлэнэ.

**8. Хүлээлгийн жагсаалт**

- Элсэлтийн шаардлага хангасан боловч тухайн ангид орон тоо байхгүй тохиолдолд сурагчийг хүлээлгийн жагсаалтад авна.
- Тохирох ангид орон тоо байхгүй үед дээд, доод ангид оруулах боломжгүй.
- Материал бүрдүүлсэн сурагчийг хүлээлгийн жагсаалтад бүртгэн авч эцэг эхэд мэдэгдэнэ.
- Хүлээлгэнд байгаа сурагчийг өргөдлөө өгсөн дараалалын дагуу эргэн элсүүлнэ.

**9. Туршилтын хугацаа**

- Шаардлагатай тохиолдолд сурагчид тухайн хичээлийн жилийн туршид туршилтын хугацаа өгнө. Туршилтын хугацаанд тухайн сурагч сурлага, хэлний түвшин, хүмүүжлийн хувьд хоцрогдож байгаа эсэх, сургалт харилцан үр нөлөөтэй байгаа эсэхийг харна.

**10. 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр төлөх хугацаа**

- 1-р семестрийн төлбөрийг 2024 оны 8-р сарын 14-ны дотор төлнө.
- 2-р семестрийн төлбөрийг 2024 оны 12-р сарын 4-ны дотор төлнө.
- Семестр эхэлснээс хойш 10 хоногийн дотор төлбөр нь төлөгдөөгүй сурагчийг сургуулиас хасах арга хэмжээ авна.

**11. Шинээр элсэн орж байгаа сурагчийн насанд тавих шаардлага**

<b>Анги</b>	<b>Төрсөн он, сар:</b>
<b>Бэлтгэл</b>	Oct 2018, Nov 2018, Dec 2018, Jan 2019, Feb 2019, March 2019, April 2019, May 2019, June 2019, July 2019, Aug 2019, September 30, 2019
<b>1-р анги</b>	Oct 2017, Nov 2017, Dec 2017, Jan 2018, Feb 2018, March 2018, April 2018, May 2018, June 2018, July 2018, Aug 2018, September 30, 2018
<b>2-р анги</b>	Oct 2016, Nov 2016, Dec 2016, Jan 2017, Feb 2017, March 2017, April 2017, May 2017, June 2017, July 2017, Aug 2017, September 30, 2017
<b>3-р анги</b>	Oct 2015, Nov 2015, Dec 2015, Jan 2016, Feb 2016, March 2016, April 2016, May 2016, June 2016, July 2016, Aug 2016, September 30, 2016
<b>4-р анги</b>	Oct 2014, Nov 2014, Dec 2014, Jan 2015, Feb 2015, March 2015, April 2015, May 2015, June 2015, July 2015, Aug 2015, September 30, 2015
<b>5-р анги</b>	Oct 2013, Nov 2013, Dec 2013, Jan 2014, Feb 2014, March 2014, April 2014, May 2014, June 2014, July 2014, Aug 2014, September 30, 2014